

**МОНГОЛ УЛСАД ИРГЭНИЙ ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГЫН ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

З.ЛХАГВАДОРЖ

Дотоод хэргийн их сургуулийн

Гэмт явдал судлал-эрх зүйн 7051 дүгээр дамжааны
магистрант, ахлах дэслэгч

Товч агуулга: Энэхүү судалгааны ажилдаа шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангах иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгохыг өөрийн үзэл бодлоор онолын тодорхойлолт гаргах, дотоодын болон гадаадын хууль тогтоомжид иргэн захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоог хэрхэн зохицуулсныг ажиглалт хийх, тодорхой үндэслэл гарган, холбогдох шийдэл гарган судалгаа хийж ажиллаа. Судалгааны ажлын сэдэв нь харьцангуй онолын хувьд өргөн агуулгатай хамрах хүрээ том судлагдахуун юм. Энэхүү судалгааны ажлаар иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоог судлахыг зорьсон. Судалгаагаар онолын болон практик талаас мөн дотоодын болон гадаадын эрх зүйн зохицуулалтанд иргэн захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоог хэрхэн тусгаж өгснийг харьцуулан судалсан. Судалгааны явцад ажиглахад иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага нь өөрөө гүйцэтгэх эрх мэдэл буюу засгийн газрын яамны харьяанд байгаа нь тогтолцооны хувьд хэрхэвч байж болохгүй буруу шийдэл бөгөөд шүүх эрх мэдлийн хараат бус байх зарчимд шууд харшилж байна. Мөн иргэний шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа нь тогтолцооны хувьд заавал төрийн оролцоо байх шаардлагагүй хууль тогтоомж хэм хэмжээний хувьд хувиараа байж гэрээгээр гүйцэтгэж болохоор байна. Ингэснээр төсөв мөнгөний хувьд хэмнэлттэй төдийгүй төрийн оролцоогүй шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт өсөх давуу талтай гэж судлаачийн хувиар үзэж байна. Гадаадын зарим улс орнуудтай харьцуулан судлахад. Оросын холбооны

улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны алба, түүний орон нутгийн байгууллага биелүүлнэ гэж зааж өгсөн байна. Мөн бүтцийн тухайд. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны албаны тухай дүрэм, албаны бүтэц, орон тоог Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч батална гэж тусгаж өгчээ. Энэ дээр дүгнэлт хийвэл манай улстай ижил төстэй хэдийч зөвхөн ерөнхийлөгчийн эрх хэмжээнд хамаарах асуудал учир шүүх эрх мэдэл нь хараат бус байх боломжтой. Харин БНСУ-ын хууль тогтоомжинд Гүйцэтгэлийн ажиллагаа сахиулагч Иргэний гүйцэтгэлийн ажиллагааг энэ хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн ажилтан сахиулна. Гүйцэтгэлийн шүүх Энэ хуульд заасан гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг харьяалж буй эсхүл эдгээр ажиллагааг (бусад) шүүхтэй хамтран ажиллах ажиллагааны дагуу харьяалж буй гүйцэтгэлийн шүүх нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн ажиллагааг явуулах газар болон этгээдийг харьяалах дүүргийн шүүх байна гэж зааж өгсөн нь шүүх эрх мэдэлд бүрэн өөрийнхөө гаргасан шийдвэрээ хянах боломжоор хангасан гэж харж болохоор байна. Иймд судлаачийн хувиар иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэжээн тэтгэхээс бусад хэсгийг хувьд гаргаж захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагыг шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд байгуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийг шинэчлэн найруулах санал гаргаж байна.

Түлхүүр үг: Тогтолцоо, иргэний захиргааны, Хууль, засаглал, Эрх зүйн зохицуулалт, дүн шинжилгээ

Key word: System, Civil, administrative, law, governance, legal regulation, analysis

Иргэн захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцооны талаар судлахын өмнө онолын ерөнхий түвшин буюу манай улсын засаглалын тогтолцоог судлах нь зүй ёсны хэрэг гэж үзлээ. Ийнхүү судалснаар бид иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага нь засаглалын аль хэлбэр, тогтолцоонд хамаардаг, мөн цаашид аль салбарт хамаарвал зохих талаар олох юм.

1. Бидний сайн мэдэх өөрсдөө сонгож тухайн хүнээр төлөөлж үзэл бодлоо илэрхийлдэг улсын их хурлын гишүүн буюу эдгээр хүмүүс

нэгдэж улсын их хурал буюу хууль тогтоох байгууллага. Энэ нь хууль санаачилж батлах буюу явцуу утгаараа хуульчлах хэм хэмжээг тогтоох төрийн дээд байгууллага мөн.

2. Мөн бид бүгдийн ойлголтоор Ерөнхий сайд, сайд нар буюу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн дээд байгууллага. Бүх шатны төрийн албаны толгой яамдыг бодлогоор хангах гүйцэтгэлд хяналт тавих. Явцуу утгаараа засаглах буюу “процесс”-д үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг чиглэлээр хангах, үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулах байгууллага мөн.

3. Ард иргэдийн ойлголтоор шүүх буюу шүүгч нар Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, бүх шатны шүүх, Цэцийн гишүүд бүх шатны шүүгч нар, үүн дээр тайлбар хийхэд Үндсэн хуулийн цэц бол үндсэн хуулийг хамгаалах, үндсэн хууль зөрчсөн эсэхийг шийдэх субъект өөр зүйлд хамааралгүй. Үүн дээр нэмээд дурдахад шүүх эрх мэдэлд хамааруулж болохуйц байгууллага бол Шүүхийн Ерөнхий зөвлөл юм. Шүүгч нарын мэргэжлийн чадвар, ёс зүйд хяналт тавих сургалт дадлага зохион байгуулах чиг үүрэг бүхий. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага нь УИХ-аас баталсан хууль тогтоомжийн хүрээнд хараат бусаар бие даан шийдвэр гаргаж шүүн таслах, энгийн бөгөөд явцуу утгаар тайлбар хийхэд буруутай эсэхийг шийдэж иргэн, захиргаа, зөрчлийн, эрүүгийн бүх төрлийн үйл ажиллагааг шүүн таслах эрх бүхий шүүх эрх мэдлийн дээд байгууллага мөн.

Дээр дурдсан засаглалын 3 хэлбэр нэг нэгнээсээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж бие биенээ хянаж байж аль нэг нь доголдохгүй шударга байж ардчилал хөгжинө гэж онолын үүднээс үздэг. Тэгвэл өнөөдрийн байдлаар Монгол улсад хууль эрх зүйн хэм хэмжээнд иргэн захиргааны шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дараах байдлаар тусгаж өгчээ. Үүнд: Тус хуулийн хорин дөрөвдүгээр бүлгийн хоёр зуун тавин долдугаар зүйлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, удирдлага, чиг үүргийг тодорхой тусгаж өгчээ.

257 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо:

257.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн

эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага мөн.

257.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь нутаг дэвсгэрийн болон тусгайлсан чиг үүргийн зарчмаар зохион байгуулагдана.

257.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх алба /цаашид “шийдвэр гүйцэтгэх алба” гэх/, цагдан хорих шүүхийн шийдвэр, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх алба /цаашид “хорих ял эдлүүлэх алба” гэх/, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх алба /цаашид “хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба” гэх/, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс /цаашид “шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс” гэх/-ээс бүрдэнэ.

257.4.Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, газар зүйн байршил, дэд бүтэц, ял шийтгүүлсэн этгээдийн болон гүйцэтгэх баримт бичгийн тоог харгалзан сум, дүүрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийг Засгийн газрын шийдвэрээр байгуулж болно.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

257.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа алба нь хариуцсан чиг үүргийн хүрээнд хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийг нэгдсэн болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын өмнө хариуцан тайлагнана.

257.6.Хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь үйл ажиллагаагаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын өмнө хариуцан тайлагнана.

257.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд, төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий нэгж /алба хаагч/-тэй байна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

257.8.Хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн бүтэц, орон тоог шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.[1]¹

Гэж тусгаж өгчээ харин одоо сэдэвтэйгээ уяж Үндэслэл гаргаж үзье

Үндэслэл:1 Эрх зүйн онол талаас иргэний эрх зүй бол хувийн эрх зүй, иргэн хоорондын эдийн болон эдийн бус баялаг, үйл ажиллагаа гүйцэтгэх гүйцэтгэхгүй байхыг даалгах буюу тодорхой үйл ажиллагааг хуульд нийцүүлж хийх эсхүл хийхийг хориглох хэм хэмжээ, захиргааны эрх зүйн субъектийн нэг талд төрийн байгууллага албан тушаалтан, эсхүл түүний гаргасан эрх зүйн актыг шүүх эрх мэдлийн байгууллага зөв бурууг эцэслэн шийдвэрлэсэн байхад. Гүйцэтгэх эрх мэдлийн агентлаг дээр ирж хэрэгждэг байх боломжгүй. Энэ өөрөө шүүх эрх мэдлийн хараат бус байдалд шууд нөлөөлж байна.

Үндэслэл:2 Практик талаас авч үзвэл цэргийн дүрмээр захирах захирагдах ёсонд тулгуурлаж харилцааг зохицуулж байна. Мөн агентлагийн харъя байгууллага учир удирдах албан тушаалтан дээд байгууллагын шийдвэр дагах шаардлага үүсэн.

Жишээ татвал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын тушаалыг хүчингүй болгох шүүхийн шийдвэр гарахад шийдвэр гүйцэтгэгч хэрхэн гүйцэтгэх вэ.

Нэг шийдвэр гүйцэтгэгчид дунджаар Нэгжийн хүрээнд 5 системийн хэмжээнд 15-20 удирдах албан тушаалтан ажил үүргээр цол хэргэмээр холбогдож байна. Эдгээр гол хоёр үндэслэлийг үндэслэн шийдэл гарагъя:

Шийдэл:1 Шүүгч өөрийнхөө гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьдаг өөр хүний нөлөөлөлгүй Иргэн, Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах эрх зүйн бааз суурийг бий болгох.

Шийдэл:2 Шийдвэр гүйцэтгэх алба буюу Иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоог бие даалгаж шаардлагатай гэж үзвэл иргэний гүйцэтгэлийн зарим хэсгийг хувьд гаргах.

¹ [1] <https://www.legalinfo.mn/law/details/12701?lawid=12701> Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчилсэн найруулга 2017.06.09 УБ хот., 114-дүгээр хуудас 1-дүгээр тал

Хүрэх үр дүн шүүх мэдлийн хараат бус байдлыг хангаж иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчин хөгжиж, иргэдийн шүүхээр шийдүүлсэн иргэний, захиргааны процесс ажиллагаа түргэн шуурхай явагдаж иргэний эрх хангагдахад оршино.

Гадаадын зарим улс орнуудын иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцооны эрх зүйн зохицуулалт: Иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоо нь Оросын холбооны улсад “ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ”, болон “ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТУХАЙ ХОЛБООНЫ ХУУЛЬ” зэрэгт тусгаж өгчээ ингэхдээ дараах байдлаар тусгасан байна. Оросын холбооны улс гүйцэтгэх ажиллагааны тухай холбооны хуулийн/ Энэ хуулийг Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.ПУТИН Москва, Кремль 2007 оны аравдугаар сарын 2-д ХХ-№ 229 /-5 дугаар зүйлд Албадан гүйцэтгэх байгууллага нэртэйгээр дараах гурван хэсэгт хувааж тусгаж өгчээ. Үүнд

1. Шүүхийн шийдвэр, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг Холбооны энэхүү хуульд заасан журмын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны алба, түүний орон нутгийн байгууллага биелүүлнэ гэж зааж өгсөн байна. Энэ хэсэг нь (2013.04.05-нд Холбооны ХХ-№49 хуулиар засвар орсон)

2. Шүүхийн шийдвэр, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны чиг үүргийг шууд хэрэгжүүлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны албаны салбар нэгжийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны албаны орон нутгийн байгууллагуудын (цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбар нэгж гэх) шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нар биелүүлнэ. (2 дугаар хэсэгт 2013.04.05-нд Холбооны ХХ-№49 хуулиар засвар орсон)

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхийг энэхүү хууль, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай” Холбооны хууль болон холбооны бусад хуулиар тодорхойлно хэмээн тусгаж хуульчилж тогтолцоог нь зааж өгчээ.

Оросын холбооны улсад иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны тогтолцоо, бүтцийг мөн дараах хуулиар зохицуулдаг байна. Оросын холбооны улс шүүхийн гүйцэтгэгчийн тухай холбооны хууль нь 1997 оны зургадугаар сарын 4-нд Төрийн Дум баталсан 1997 оны долдугаар

сарын 3-нд Холбооны Зөвлөлөөр дэмжсэн тус хуулийн тав, зургаа дугаар зүйлүүдэд дараах байдлаар тусгаж өгчээ. Ингэхдээ Шүүхийн гүйцэтгэгч нарын үйл ажиллагааны зохион байгуулалт гэж

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны албаны тухай дүрэм, албаны бүтэц, орон тоог Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч батална. (1 дэх заалтанд 2004.06. 29-нд Холбооны ХХ-№58 хуулиар өөрчлөлт оруулсан)

2. Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх, Оросын Холбооны Улсын Дээд шүүх, Оросын Холбооны Улсын Арбитрын дээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх

албаны үйл ажиллагааны зохион байгуулалтыг Холбооны энэхүү хууль болон эдгээр шүүхүүдийн тухай холбооны үндсэн хуульд нийцүүлэн гаргасан (органик) хуулиудаар тодорхойлно.

Зургаа дугаар зүйлд Шүүхийн гүйцэтгэгчийн албан тушаалд томилох, шүүхийн гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлөх журам (2004.06. 29-нд Холбооны ХХ-№ 58 хуулиар өөрчлөлт оруулсан)

1. Оросын Холбооны Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны албаны удирдагчийг (Оросын Холбооны Улсын Шүүхийн ерөнхий гүйцэтгэгч) Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч энэ албан тушаалд томилж, энэ албан тушаалаас чөлөөлнө. (2009. 07. 19-нд Холбооны ХХ-№ 194 хуулиар өөрчлөн найруулсан)

2. Шүүхийн гүйцэтгэгчийн албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх журмыг Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч тогтооно. Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Борис ЕЛЬЦИН Москва, Кремль 1997 оны долдугаар сарын 21 ингэж тусгаж өгсөн нь нэг хүний буюу шууд ерөнхийлөгчийн эрх хэмжээнд аваачиж төвлөрүүлж өгсөн байна.^[2]

Бүгд найрамдах Солонгос улсад: , “БНСУ-ЫН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” Хуулийн дугаар 6627, огноо 2002.01.26. Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн дугаар 7358, огноо 2005.01.27. хуулийн дугаар 8581, огноо 2007.08.03. хуулийн дугаар 8622,

² “Оросын холбооны улс гүйцэтгэх ажиллагааны тухай хууль”

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.ПУТИН Москва, Кремль 2007 оны аравдугаар сарын 2-д ХХ-№ 229, 2-дугаар хуудас 1-дүгээр тал

Оросын холбооны улс шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн тухай холбооны хууль, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Борис Ельцин Москва, Кремль 1997 оны долдугаар сарын 21, 4-дүгээр хуудас 1-дүгээр тал

огноо 2007.08.03. хуулийн дугаар 9525, огноо 2009.03.25. тус хуулийн нэгдүгээр бүлэгт дараах байдлаар тусгаж өгчээ.

Нийтлэг үндэслэл 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа, барьцааны эрхийг хэрэгжүүлэх дуудлага худалдаа, Иргэний хууль, Худалдааны хууль, бусад хуулийн дагуу явуулах дуудлага худалдааны горим (цаашид иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэх) болон холбогдох хамгаалалтын арга хэмжээний горим, журмыг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Гүйцэтгэлийн ажиллагаа сахиулагч Иргэний гүйцэтгэлийн ажиллагааг энэ хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн ажилтан сахиулна.

3 дугаар зүйл. Гүйцэтгэлийн шүүх (1) Энэ хуульд заасан гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг харьяалж буй эсхүл эдгээр ажиллагааг (бусад) шүүхтэй хамтран ажиллах ажиллагааны дагуу харьяалж буй гүйцэтгэлийн шүүх нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн ажиллагааг явуулах газар болон этгээдийг харьяалах дүүргийн шүүх байна. (2) Гүйцэтгэлийн шүүхийн шийдвэрт гаргасан аливаа гомдлыг үл харгалзан түүнийг гүйцэтгэж болно. Үүнээс хархад Гүйцэтгэлийн шүүх буюу шүүх эрх мэдэлд иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа нь хэрэгждэг байна. Түүнийг гүйцэтгэлийн ажилтан сахиулдаг байна.^[3]

Дүгнэлт

Судлаачийн хувиар Иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ гэх сэдвээр судалгааны ажил бичихдээ монгол улсын засаглалын хэлбэр, өөрийн мэргэжлээрээ ажилласан туршлага мөн өнөөгийн үйлчилж буй хууль эрх зүйн орчинд хэрхэн тусгагдсан байдлыг судалж учир дутагдалтай талыг олж илрүүлж засан сайжруулах арга замыг эрэлхийлж шийдвэрлэвэл зохих өөрийн санал бодлоо илэрхийлсэн. Мөн гадаадын зарим улс орны хууль эрх зүйн орчинд иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны тогтолцоог хэрхэн тусгаж өгсөн

³ “БНСУ-ын иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль” Хуулийн дугаар 6627, огноо 2002.01.26. Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн дугаар 7358, огноо 2005.01.27. хуулийн дугаар 8581, огноо 2007.08.03. хуулийн дугаар 8622, огноо 2007.08.03. хуулийн дугаар 9525, огноо 2009.03.25., 1-дүгээр хуудас 1-дүгээр тал

манайд авч хэрэгжүүлж болох заалтыг бүрэн эхээр нь судлав. Миний бичсэн судалгааны давуу тал нь практик, онол хоёрыг харьцуулж ардчиллын үндсэн суурь зарчимд нийцүүлэн үндэслэл гаргаж шийдвэрлэх арга замыг олох мөн гадаадын зарим улс оронтой харьцуулан судлахаар тойм байдлаар эрэл хайгуулын шийдэл хайсан судалгааны ажил байлаа.

Шинээр дэвшүүлсэн санааг товч байдлаар дурдвал

1. Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулж бүтэц тогтолцоонд нь өөрчлөлт оруулах Захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагыг шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд байхаар тусгаж өгөх ингэснээр шүүх эрх мэдлийн хараат бус байдал хангагдаж захиргааны хэм хэмжээг зөрчсөн хууль бус актуудыг засан сайжруулах дахин давтан алдаа гаргахгүй байх эрх зүйн орчин бүрдэн.

2. Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулж бүтэц тогтолцоонд нь өөрчлөлт оруулах иргэний шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тодорхой хэсгийг хувьд гаргахаар гэрээгээр зохицуулахаар эрх зүйн орчин бааз суурийг бий болгохоор тусгаж өгөх ингэснээр шүүх эрх мэдэлийн хараат бус байдал хангагдаж иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн бодит биелэлт нэмэгдэж хохирсон иргэд шүүхээр бүрэн гүйцэт эрхээ хамгаалуулах бодит эрх зүйн орчин бүрдэн.

3. Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулж бүтэц тогтолцоонд нь өөрчлөлт оруулах иргэний шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тэжээн тэтгэх үүрэг буюу хүүхдийн тэтгэлэг төлүүлэхтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг захиргааны шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаатай хамт шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд байгуулж өгөх ингэснээр шүүх эрх мэдлийн хараат бус байдал хангагдаж иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн бодит биелэлт нэмэгдэж хохирсон иргэд шүүхээр бүрэн гүйцэт эрхээ хамгаалуулах бодит эрх зүйн орчин бүрдэн.

Хүрэх үр дүн нь шүүх эрх мэдлийн тогтолцоо сайжрах, шийдвэр гүйцэтгэл бодит биелэлт нэмэгдэх, хохирсон иргэний эрхийг хурдан шуурхай хангах хууль хэрэгжилт сайжрах, байгууллагын нэр хүнд дээшлэх хууль засагладаг нийгэм бий болгоход чиглэнэ.

Ашигласан эх сурвалж

Ашигласан хууль :

1. <https://www.legalinfo.mn/law/details/12701?lawid=12701> Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчилсэн найруулга 2017.06.09 УБ хот., 114-дүгээр хуудас 1-дүгээр тал

2. “БНСУ-ын иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль” Хуулийн дугаар 6627, огноо 2002.01.26. Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн дугаар 7358, огноо 2005.01.27. хуулийн дугаар 8581, огноо 2007.08.03. хуулийн дугаар 8622, огноо 2007.08.03. хуулийн дугаар 9525, огноо 2009.03.25., 1-дүгээр хуудас 1-дүгээр тал

3. Оросын холбооны улс гүйцэтгэх ажиллагааны тухай хууль”

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.ПУТИН Москва, Кремль 2007 оны аравдугаар сарын 2-д ХХ-№ 229,. 2-дугаар хуудас 1-дүгээр тал

4. Оросын холбооны улс шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн тухай холбооны хууль, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Борис Ельцин Москва, Кремль 1997 оны долдугаар сарын 21,. 4-дүгээр хуудас 1-дүгээр тал

Ашигласан тогтоол:

1. Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 11-дүгээр сарын 29-ний өдрийн /43/-дугаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай

Улаанбаатар хот

Ашигласан ном сурах бичиг гарын авлага:

1. А.Дугармаа, Б.Оюунбадам, Хурандаа Б.Алтангэрэл нарын бүтээл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн гарын авлага Улаан баатар хот 2013 он

Ашигласан интернет вэб сайт:

1. <https://www.legalinfo.mn/>
2. <http://resource3.sodonsvision.com/courtservice/file/2013/5/3see5ekdqjk m3s5wyse82c83q/Zavhan%20Erdenetuya.pdf>
3. <https://advocate.mn/news/119/single/1007>